

АГУУЛГА

ОРШИЛ.....	2
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн товч тодорхойлолт	3
1.2 2025 онд явагдах уулын ажил, ажиллах горим.....	5
1.3 Ил уурхайн хүчин чадал, техник-технологии	6
1.3.1 Ил уурхайн хүчин чадал	6
1.3.3 Ил уурхайн үндсэн хэмжээсүүд	6
1.4 2025 оны уулын ажлын төлөвлөгөө.....	6
1.5 Баяжуулалтын технологи	7
1.5.1 Баяжуулах хэсгийн ажиллах горим, хүчин чадал.....	7
1.6. Дэд бүтэц.....	8
1.6.1 Усан хангамж	8
1.6.2 Цахилгаан хангамж	8
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	9
2.1 Физик газарзүйн нөхцөл.....	9
2.2 Уур амьсгал.....	9
2.3 Физик бохирдол, хог хаягдал	9
2.4 Геологийн тогтоц ба геоморфологи	9
2.5 Гадаргын болон газрын доорхи ус.....	10
2.6 Хөрсөн бүрхэвч	10
2.7 Ургамлан нөмрөг.....	10
2.8 Амьтны аймаг	10
2.9 Тусгай хамгаалалттай газар нутаг	10
2.10 Түүх соёлын өв	10
2.11 Нийгэм эдийн засгийн байдал.....	10
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	11
3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл..	11
3.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	11
3.3 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	11
3.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл...	11
БҮЛЭГ 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
БҮЛЭГ 5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
БҮЛЭГ 6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	17

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
БҮЛЭГ 9. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	21
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	25
БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ДҮН..	26

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол.....	3
Хүснэгт 2. Ашиглалтын технологи	5
Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим ба хугацаа	5
Хүснэгт 4. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд.....	6
Хүснэгт 5. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	7
Хүснэгт 6. Угаах процесст зарцуулагдах усны хэрэгцээ.	8
Хүснэгт 7. Уурхайн нийт усны хэрэглээ	8
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	12
Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	16
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө	17
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	22
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24
Хүснэгт 14 Менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлагнах хуваарь.....	25
Хүснэгт 15 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	26

Хавсралтын жагсаалт

Хавсралт : Барьцаа төлсөн баримт.....	27
---------------------------------------	----

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ОРШИЛ

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших Цагаан чулуут хоолойн дунд хэсэг нэртэй MV-003108 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордын 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2025 оны Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, болон бусад материалд үндэслэн БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А-618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу боловсруулав.

“Цагаан чулуут хоолойн дунд хэсэг” нэртэй 380.32 га бүхий MV-003108 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 10-р сарын 10-ны өдрийн 51 тоот шийдвэрээр “ХОТУ” ХХК-д шилжүүлсэн байна. Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордын доод давхарга нь алттай дан давхаргаас бүрдэх ба харьцангуй бага уналтай тэвш маягийн U хэлбэрийн хөндийг дагаж тогтсон, аллювиаль-пролювиаль гаралтай голын сэвсгэр хурдсанд хуримтлагдсан, тууз хэлбэрийн энгийн тогтоцтой, III бүлгийн орд юм. Ордын ашигт давхарга суналын дагуу тогтоогдсон бөгөөд ерөнхийдөө тууз хэлбэрийн тогтоцтой алт агуулсан хурдас нь нийлмэл тогтоцтой, дунд зэрэг мөлгөржсөн, 700 метр урттай, дундаж өргөн 60 метр, дундаж гүн 21 метр байна.

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч тодорхойлолт

Төсөл хэрэгжүүлэгч: “Хоту” ХХК

Регистрийн дугаар:

Төслийн нэр: “Цагаан чулуут хоолойн дунд хэсэг”-ийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл

Төслийн байршил:


“Цагаан чулуут хоолойн дунд хэсэг” нэртэй MV-003108 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй судалгааны талбай нь засаг захиргааны хуваариар Монгол улсын зүүн хойд хэсэг, Дорнод аймгийн Баяндун сумын нутагт харьяалагдах бөгөөд улсын геодезийн нэгдсэн номинклатурын М-49-95, 96 хавтгайд байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 704 км, Баяндун сумаас хойд зүгт 35 орчим километрийн зайнд байрлана.

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	113	25	32.01	49	32	19.01
2	113	24	32.01	49	32	19
3	113	24	32.01	49	32	2
4	113	25	23.62	49	32	2.01
5	113	25	23.62	49	31	40.01
6	113	25	50.01	49	31	40.01
7	113	25	50.01	49	31	25.14
8	113	26	12.01	49	31	25.14
9	113	26	12.01	49	30	34.01
10	113	26	38.01	49	30	34.01
11	113	26	38.11	49	29	53.95
12	113	27	32.12	49	29	53.95
13	113	27	32.01	49	30	19.01
14	113	27	2.02	49	30	19.01
15	113	27	2.02	49	30	42
16	113	27	32.01	49	30	42

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

17	113	27	32.01	49	31	10
18	113	27	18.63	49	31	10
19	113	27	18.62	49	30	57.6
20	113	26	52.37	49	30	57.6
21	113	26	52.37	49	30	42.07
22	113	26	27.98	49	30	42.07
23	113	26	27.98	49	31	44.01
24	113	26	2.02	49	31	44.01
25	113	26	2.02	49	32	2.01
26	113	25	32.01	49	32	2.01
27	113	25	32.01	49	32	19.01



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.2 2025 онд явагдах уулын ажил, ажиллах горим

Ордыг ашиглах технологи: Ордыг ил аргаар ашиглах бөгөөд уулын ажил явуулах ашиглалтын системийг ордын уул-геологийн нөхцөл, геологийн тогтоц, ордын ашиглалтын хэтийн төлөв байдал зэргийг үндэслэн тээвэртэй гадаад, дотоод хосолмол овоолготой ашиглалтын системээр явуулахаар төлөвлөв.

Доголын өндөр: Уурхайн хөрсний зузаан болон элсний зузааны нийлбэр дунджаар 23 м байна. Тиймээс ажлын доголын өндөр 3.5 м ажлын бус догол 7 м байхаар төлөвлөв. Доголын аюулгүйн зай 2.5 м, траншейн 10 градус. Ажлын доголын хажуугийн өнцөг: Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн шинж чанар, аюулгүй ажиллагаа зэргийг тооцож $\alpha=55$ градус байхаар сонгосон.

Доголын өндөр: Уурхайн хөрсний зузаан болон элсний зузааны нийлбэр дунджаар 23 м байна. Тиймээс ажлын доголын өндөр 3.5 м ажлын бус догол 7 м байхаар төлөвлөв. Доголын аюулгүйн зай 2.5 м, траншейн 10 градус.

Ажлын доголын хажуугийн өнцөг: Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн шинж чанар, аюулгүй ажиллагаа зэргийг тооцож $\alpha=55$ градус байхаар сонгосон.

Хүснэгт 2. Ашиглалтын технологи

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процесс
Авто тээвэртэй ашиглалтын систем	Хөрс хуулалт	Ухаж ачих
		Тээвэрлэх /Гадаад, дотоод овоолго/
	Элс олборлолт	Ухаж ачих
		Тээвэрлэх /Угаах үйлдвэр/

Ажиллах горим: Уурхай нь 2025 онд 3-р сарын 01-ээс бэлтгэл ажлыг эхлүүлж, 4-р сарын 1-ээс 9-р сарыг дуустал хөрс хуулах, элс олборлох, элс угаах, нөхөн сэргээлт хийх болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 12 цагийн уртасгасан хугацаагаар явагдана. Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, усан сан байгуулах болон угаан баяжуулах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим ба хугацаа

№	Үзүүлэлтүүд	Хугацаа	Эхний жил
1	Хуанлийн өдөр	хоног	365 хоног
2	Уурхайн бэлтгэл ажлын хоног	хоног	30 хоног
3	Жилд ажиллах ажлын хоног	хоног	180 хоног
4	Баяр ёслол	хоног	7 хоног
5	Төлөвлөгөөт бус сул зогсолт	хоног	13 хоног
6	Уурхайн цэвэр ажлын хоног	хоног	160 хоног

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

8	Баяжуулах хэсгийн ажиллах хоног	хоног	130 хоног
9	Хоногийн ээлжийн тоо	-	2
10	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12 цаг

1.3 Ил уурхайн хүчин чадал, техник-технологи

1.3.1 Ил уурхайн хүчин чадал

2025 оны 3-р сард уурхайн бэлтгэл ажлыг хангаж, Цагаан чулуут хоолойн уурхайд манай компанид бэлэн байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд уулын ажлаар 32.54 мян.м3 алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана.

1.3.2 Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа техник, тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан үргэлжлүүлэн ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан 2024 оны бүтээлийн тооцоог гүйцэтгэв. Ил уурхайн үндсэн технологийн процесс нь өнгөн хөрсийг бульдозероор хуулж овоолгод байршуулах, хөрсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж гадаад, дотоод овоолгод байршуулах, алттай элсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж баяжуулах үйлдвэрийн хажууд овоолгод байршуулах зэрэг ажил гүйцэтгэнэ.

1.3.3 Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

Ордын хөрсний зузаан 2025 онд 20.6-20.9 м, элсний зузаан 1.3- 1.4 м байгаа тул уурхайн гүн 25 м орчим байхаар байна. Иймээс хөрс хуулалт, элс олборлолтын ажил болон ил уурхайд ажиллах техник тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг үндэслэн ил уурхайн үндсэн хэмжигдэхүүнийг дараах байдлаар сонголоо.

Хүснэгт 4. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Үзүүлэлт
1	Хөрс хуулалтын доголын өндөр	м	3.5
2	Элс олборлолтын доголын өндөр	м	2
3	Мөргөцгийн налуугийн өнцөг	градус	55°
4	Авто замын өргөн	м	12
5	Авто замын налуугийн хэмжээ	‰	80
6	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн	м	20

1.4 2025 оны уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2025 оны 03-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

Тухайн жилд ашиглах блокуудын шимт хөрсийг ялган бульдозероор түрж блокын хилийн гадна шимт хөрсний овоолгод байршуулж үндсэн хөрсийг экскаватор, автосамосвал ашиглан гадаад болон дотоод овоолгод шилжүүлэн байршуулахаар төлөвлөв.

2025 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр цагаан чулуут хоолойн доод давхаргын 4-В,5-С блокуудыг өмнөх оны үлдэгдэл болох Жалга 5-ын V-В-1, V-В-2, V-В-4 блокуудыг олборлоно. Энэ онд 595.05 мян.м3 хөрс хуулж, химийн цэврээр 11.42 кг алт бүхий

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

32.54 мян.м³ элс олборлоно. Энэ онд уурхайн урт 490 м, өргөн дунджаар 100 м, уурхай нийт 5 га талбайг эзэлж байна.

Календарь төлөвлөлт

Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг жилийн хүчин чадал, ордыг ашиглах хугацаатай уялдуулж 2025 онд 32.54 мян.м³ элс олборлон баяжуулахаар тооцлоо.

Хүснэгт 5. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 онд			Нийт
			II-р улирал	III-р улирал	IV-р улирал	
1	Уулын цул	мян.м ³	159.69	319.39	159.71	627.59
2	Нийт хөрс хуулалт:		154.7	302.7	148.85	595.05
	Үржил шимт хөрс хуулалт	мян.м ³	6.0	5.2	11.2	
	Хөрс хуулалт	мян.м ³	148.7	286.3	148.85	583.85
3	Элс олборлолт	мян.м ³	7.24	15.2	10.1	32.54
4	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³	12.2	14.4	12.7	13.1
5	Угаах элсний хэмжээ	мян.м ³	7.24	15.2	10.1	32.54
6	Дундаж агуулга	мг/м ³	472.3	468.4	445.9	462.2
7	Металлын хэмжээ /шлихээр/	кг	4.0	6.4	5.0	15.4
8	Металлын хэмжээ /химийн цэврээр/	кг	3.1	5.5	3.7	12.32
9	Металл авалт	%	92.83	92.83	92.83	92.83
10	Металлын хэмжээ /шлихээр/	кг	3.2	6.7	4.4	14.3
11	Металлын хэмжээ /химийн цэврээр/	кг	2.5	5.2	3.7	11.42

1.5 Баяжуулалтын технологи

1.5.1 Баяжуулах хэсгийн ажиллах горим, хүчин чадал

Ордын баяжуулах хэсгийн ажиллах горим нь манай орны улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, ил уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, уурхайн жилийн хүчин чадал зэрэгтэй уялдаж ажиллана. Баяжуулах хэсэг 2025 онд 32.54 мян.м³ элс баяжуулах ба дунджаар 130 хоног ажиллана. Нийт 595.05 мян.м³ хөрс хуулж, дунджаар 462.2 мг/м³ агуулгатай 32.54 мян.м³ элс олборлон баяжуулж 11.42 кг алт /химийн цэврээр/ гарган борлуулахаар байна.

1.6. Дэд бүтэц

1.6.1 Усан хангамж

Технологид шаардлагатай усны хэмжээ:

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжид хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана. Алт олборлож байгаа уурхайнуудын туршлага, үүсмэл нуурын шүүрэлт, усны ууршилт, алдагдал, ордын талбайтай зэргэлдээ олборлолт явуулж байгаа ордын нууруудын шүүрэлт зэргийг үндэслэн шаардагдах усны 15%-ийг цэвэр усаар сэлбэх ба 85%-ийг технологийн эргэлтийн усаар хангах боломжтой байна. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м³ элс угаахад 2.11 м³ ус хэрэглэхээр тооцоолов.

Хүснэгт 6. Угаах процесст зарцуулагдах усны хэрэгцээ.

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 онд			Нийт уулын ажлын хэмжээ
			II-р улирал	III-р улирал	IV-р улирал	
1	Угаах элсний хэмжээ	мян.м ³	7.24	15.2	10.1	32.54
2	1 м ³ элс угаахад зарцуулах усны хэмжээ	м ³	2.11	2.11	2.11	2.11
3	Технологит зарцуулах нийт усны хэмжээ	мян.м ³	20.5	28.7	21.02	70.22
	Цэвэр усны хэмжээ 15%	мян.м ³	2.6	4.433	3.5	10.533
	Эргэлтийн усны хэмжээ 85%	мян.м ³	15.4	23.8	20.5	59.7

Хүснэгтээс үзэхэд угаах процесст зарцуулах цэвэр усны хэмжээ 2025 онд 10.533 мян.м³ байна. Нийт зарцуулагдах усны 85%-ийг эргэлтэд оруулж 15%-ийг цэвэр усаар сэлбэнэ. Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэнэ.

Унд ахуйн усны хэрэглээ

Уурхай нь улирлын чанартай ажиллах ба уурхайн хотхонд байнга 51 хүн ажиллаж амьдарна. Оршин суугч нэг хүний хоногийн усны хэрэглээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар нэг ажилчны ээлжинд буюу ажлын байранд хэрэглэх халуун болон хүйтэн усны хэрэглээ 20-200л/хон байна. Хоногт зарцуулагдах хэрэглээний усны 1 хүнд оногдох хэмжээ дунджаар 150 л гэж үзвэл, нийт хэмжээ 7650 л буюу 7.6 м³/хон (0.09 л/сек) болно. Унд ахуйн усны хэрэгцээг хотхонд гаргасан гүний худгаас хангахаар төлөвлөв.

Хүснэгт 7. Уурхайн нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 онд
1	Технологийн замын тоосжилт дарах	м ³ /жил	8280
2	Баяжуулах үйлдвэрт	м ³ /жил	10533
3	Унд ахуйд	м ³ /жил	846
	Нийт	м ³ /жил	2606

1.6.2 Цахилгаан хангамж

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Физик газарзүйн нөхцөл

Монгол орны физик газарзүйн мужлалд нь 4 их мужид хуваагддаг. Үүнд: Хангай Хэнтийн уулархаг их муж, Алтайн уулархаг их муж, Монголын Дорнод талын их муж, Говийн их мужууд ордог. Их муж дотроо мужид, муж дотроо тойрогт хуваагдана.

Баяндун сум нь физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужид багтах бөгөөд Хэнтийн захын хэсгийн тойрогт хамрагдана. Байгалийн нөхцөл байдлаараа уул, хөндий, ой хөвч хосолсон ус, ургамал ногоо жигдэрсэн, ан амьтнаар баялаг нутаг юм. Бутлаг өвслөг ургамалтай, уулын хар хүрэн, жинхэнэ хүрэн хөрс зонхилсон дундаж өндөр уулс, уулс хоорондын хөндий бүхий газар нутагтай.

Талбайн өмнө хэсэгт өргөрөгийн дагуу Улз голын уулс хоорондын хотгор 10 км хүртэл өргөнтэй зурвас хэлбэрээр оршино. Улз, Түргэн голын уулзвар хэсэгт хотгорын өргөн хамгийн их бөгөөд, энд Бүүргэний их нуур (Цагаан нуур), Бүүргэний бага нуруунд орших ба үнэмлэхүй хотгор нь 790 м юм.

2.2 Уур амьсгал

Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай ба өвөлдөө хур тунадас багатай дулаахан, зундаа хур бороо элбэг байдаг. Агаарын жилийн дундаж хэм 2 - 4 хэм, үнэмлэхүй хүйтэн -36 хэм, үнэмлэхүй дулаан +33 хэм. Хур тунадасны жилийн дундаж 219 мм ба үүний 75 % нь 6 - 8 сард унадаг. Салхины чиг голдуу баруун хойноос чиглэлтэй ба ихэвчлэн салхины хурд хавар 18 - 20 м/сек байна. Хаварт хүчтэй шороон шуурга шуурдаг.

2.3 Физик бохирдол, хог хаягдал

Төслийн талбайд уурхайн ажилчдын байр засварын газрын ойролцоо орчны газрын гадарга, хөрсөн бүрхэвч ахуйн шингэн болон хатуу хог хаягдал болон уурхайн тээвэр олборлолтын үйл ажиллагаанаас хүчтэй эвдрэл элэгдэлд орж орчны доройтол ихээр үүссэн байна. Уурхайн үйл ажиллагаанд бэлтгэх зорилгоор ургамал болон хөрсний өнгөн хэсгийн хуулалт, хөрс хуулалт, буцааж булах үйл ажиллагаа, тээвэрлэлт болон хаягдал байршуулах зэрэг үйл ажиллагаанаас агаарт тоосжилт их хэмжээгээр үүсэх, алт угаах үйл ажиллагаа, шигшиж, бутлах үйл ажиллагаа зэргээс их хэмжээний дуу чимээ үүсэх, хог хаягдлын хадгалалтаас агаар, хөрс орчинд үнэр үүсэх бохирдлууд байна.

2.4 Геологийн тогтоц ба геоморфологи

Уулс хоорондын хотос, уулс дотоодын хөндий, хотгор дахь элэгдлийн хэв шинжит өргөгдмөл хотгор гүдгэрт дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх элэгдлийн давхаргад хавтгайдуу долгиот тал болон ялимгүй сэргэж хэлбэршсэн, нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий үлдмэл уул (хяр, зоо) ихээхэн хэрчигдсэн үлдмэл дундаж өндөр уулс, сул хэрчигдсэн үлдмэл дундаж өндөр уулс, ихээхэн хэрчигдсэн үлдмэл нам уулс, сул хэрчигдэлтэй хярласан үлдэц нам уулс, жижиг толгодлог уулс багтаж байна.

Тэгширмэл газар, уулс хоорондын ба уулс дотоодын хотгор, голын хөндий дэх хуримтлалын хэв шинжит хотгоруудад гүдгэрт голын татам ба ангилагдаагүй татмын нам дэнж бүхий аллювийн тал орчин үеийн татам, сайрын хөндий ба ёроол (Түр зуурын урсгалтай

голын хөндий), ширгэдэг нуурын ёроолын ба хужир марзат тал нуур-аллювийн талууд орж байна. Геологийн судалгаагаар тогтоогдсон хагарлууд нэлээд байна.

2.5 Гадаргын болон газрын доорхи ус

Төслийн талбай нь Усны ай саваар Номхон далайн ай савт багтдаг байна. Номхон далайн ай сав газарт Монголын Дорнод хэсгийг усжуулах Онон, Улз, Хэрлэн, Халх тэдгээрийн цутгал голууд орно. Том жижиг бүх гол горхи эдгээрийн аль нэгд усаа нийлүүлж бүхэл бүтэн гол мөрний сүлжээг бүрдүүлэх бөгөөд зарим томоохон нэг нь тус улсын нутгаас гадагш нэвтрэн гарч улмаар далай тэнгист цутгах том голуудын эх болно.

2.6 Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайд уулын хар хүрэн болон жинхэнэ хүрэн хөрс тархсан байна.

2.7 Ургамлан нөмрөг

Ургамалжилтын судалгааны үр дүнд төслийн талбай түүний орчимд хээрийн бүсэд хамаарна. Уг бүсэд хуурайсаг, чийгсүү- хуурайсаг, хуурайсуу- чулуусаг бүлгийн ургамлууд зонхилон ургадаг. Хуурай хээрт Криловын хялгана (*Stipa krylovii*), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa*), Том хялганат (*Stipa grandis*), Нангиад түнгэт (*Leymus chinensis*), Саман ерхөгт (*Agropyron cristatum*), Жижигнавчит харгана (*Caragana microphylla*) бүхий бүлгэмдлүүд зонхилдог.

2.8 Амьтны аймаг

Төслийн талбайд тарвага, халиун буга, зэрлэг гахай, цагаан зээр, бор гөрөөс, туулай, чандага, хярс зэрэг амьтан нутаглана.

2.9 Тусгай хамгаалалттай газар нутаг

Баяндун сумын хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалтад авсан 5 байршлын 202915.0 га, улсын тусгай хамгаалалтад авсан 1 байршлын 35850.2 га газар байна. Улсын тусгай хамгаалалттай газар нь “Угтам уул-БНГ”, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт “Бэрх”, “Барчин”, “Цог дэлгэр”, “Хархираа өндөр, Заяат уул”, “Баяндун уул” зэрэг газруудыг хамарч байна.

2.10 Түүх соёлын өв

“Хоту” ХХК-ийн төсөл хэрэгжих MV-003108 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй байна. Төслийн хэрэгжилтийн явцад ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомж буюу МУ-ын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Баяндун сумын засаг захиргааны байгууллага, ШУА, Палеонтологийн хүрээлэн /70118283/, Түүх угсаатны зүйн хүрээлэн /11-458305/-д нэн даруй мэдэгдэх шаардлагатай.

2.11 Нийгэм эдийн засгийн байдал

Баяндун сумын хүн амын ихэнх нь буриад бөгөөд бусад аймаг сумуудаас нүүдэллэн ирсэн халх, үзэмчин барга бусад ястнууд амьдарч байна. Энэ нутгийн ард түмэн нүүдлийн мал аж ахуй голлон эрхлэхээс гадна хүнсний төрөл бүрийн ногоо бага хэмжээгээр тариалдаг. Сум нь дөрвөн багтай баг бүр нь өөрийн төвүүдтэй, сум ба багийн төвүүд дээр амьдардаг хүмүүс нь улсын байгууллага, хоршоолол, компаниудад ажиллах буюу хувиараа ажил хөдөлмөр эрхэлдэг байна.

Нийгэм эдийн засгийн хувьд уг төсөл хэрэгжсэнээр нийт 51хүнийг ажлын байраар хангах, улс орон нутгийн төсөвт татвар хураамж төлөх зэргээр эерэг нөлөөтэй байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2025 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсч агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2025 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

БҮЛЭГ 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хоту” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй.

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм;	Мот/цаг, засвар үйлчилгээ	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82
		Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг тогтмол усалж байна.	Дотоод тээврийн зам, биологийн нөхөн сэргээлтийн талбай	Нэгж усалгаа	500 000		
		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ.	Уурхайд ашиглагдаж буй замууд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд		
		Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон		

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Дотоод үйл ажиллагааны зардалд		
		Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Эрчим хүчийг хэмнэж үр ашигтай зарцуулах	Уурхайн хэмжээнд		500 000		
	Нийт	1 000 000					
2.	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө	Дотоод үйл ажиллагааны зардалд			Төслийн хугацаанд	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
		Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх - Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	1 500 000				
		Хаягдал ус зайлуулах гэрээ болон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах	Дотоод үйл ажиллагааны зардалд				
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон				
Нийт		1 500 000					

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Дотоод үйл ажиллагааны зардалд			Төслийн хугацаанд	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Уурхайн хуулсан Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих ургамалжуулах зардал , нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглаж буй тооцоог хянах, бүртгэл хөтлөх	Шимт хөрсний овоолго	Хөтөлсөн бүртгэл	200 000	2025 онд	
		Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах	Засвар үйлчилгээний талбай	Хамгаалсан талбай	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	
		Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын талбай, авто зогсоол, карьер	Саармагжуулах материал	1 500 000	Төслийн хугацаанд	
Нийт		1 700 000					
4	Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Олон салаа зам гаргахгүй байна.	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх		Олгосон зөвшөөрөл , бүртгэл			

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхон, засварын талбайд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	300 000	Төслийн хугацаанд	
		Ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой сургалт хийх	Уурхайн хэмжээнд	-	-	2 жилд 1 удаа	
Нийт			300 000				
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 4 500 000							

БҮЛЭГ 5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны эцсийн байдлаар нийт 3.72 га газар эвдрэлд өртөх ба 2025 онд 3.72 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт, 5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөв. Биологийн нөхөн сэргээлтийг нөхөн сэргээлтийн эрх бүхий мэргэжлийн байгууллагын тусламжтай хийхээр төлөвлөж байна. 0.5 га талбайд шимт хөрсний овоолгын нөхөн сэргээлтийн тус тус хийхээр төлөвлөж байна.

✓ Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

✓ Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налуугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

✓ Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай.

Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Техникийн нөхөн сэргээлт	га	3.72	-	-	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага “MNS 5918:2008”
2.	Биологийн нөхөн сэргээлт	га	5	-	8 000 000	
3.	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	ш	200	20000	4 000 000	
	Нийт				12 000 000	

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хоту”ХХК нь дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баяндун сумын засаг даргын өгсөн чиглэлийн дагуу тарвага нутагшуулах ажлыг төлөвлөөд байна. Хустайн нурууны байгалийн цогцолбор газраас 20 ш тарвага (*Marmota sibirica*)-г Дорнодын Баяндун сумын нутагт нутагшуулахаар төлөвлөж байна. Энэхүү ажлыг Амьтны мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутгийн саналаар монс, үрэл зэрэг жимсний модны төгөл байгуулах ажилд хамтран оролцох бөгөөд орон нутгаас заасан газарт 200ш мод тарихаар төлөвлөөд байна.

Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	20 ш тарвага нутагшуулах ажил	ш	20	-	2000000	5-10 сард	
2	2025 онд 200 ш мод заасан чиглэлд тарихаар төлөвлөв	ш	200		1270000	5-10 сард	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд
Нийт					3270000		

БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хоту”ХХК-ний “Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Баяндун сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Болзошгүй зардалд **500 000** төг төсөвлөсөн.

БҮЛЭГ 9. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

БҮЛЭГ 10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын цэг засвар хийх, хатуу хог хаягдлыг доторжуулах, зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хог хаягдлын цэгт хаях.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21 -р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл
		Хог хаягдлын төлбөрөө төлнө.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
		Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал	500 000	Үйл ажиллагааны турш	
		Ахуйн бохир орчмын хөрсөнд бактерлогийн шинжилгээ хийлгэх	Орчны хяналт шинжилгээний ажилд орсон	5-р сард	
		Хог хаягдал, ялган ангилалт, түүний үр ашгийн талаар сургалт, мэдлэг олгох	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
		Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялган тушаах	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
		Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын хэмжээг тогтоож орон нутагт улирал тутамд мэдээлж байна.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
2.	Үйлдвэрийн	Уурхайн техникүүдийн засварын цех, мөн уурхайн техникт ашигласан, сольсон тос маслыг сар бүр тусгайлсан савт хуримтлуулна.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Хаягдал техникийн тос, масло хуримтлуулах /сар болгон аюултай хаягдлаа 1 удаа гэрээ хийсэн газарт нийлүүлэх зайлуулах/			
		Уул уурхайн тоног төхөөрөмжөөс гарах нефтийн бүтээгдэхүүний үлдэгдэл хаягдлыг хаягдал зайлуулах газарт шилжүүлэн хаяна.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
Нийт зардал 2 500 000					

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах төлөвлөгөө авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- ✓ Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө боловсруулах
- ✓ Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2025 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаар төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Агаар	Нөхөн сэргээлт хийсэн талбай, Засварын талбай ажилчдын хотхон, уурхайн карьер, уурхайн зам	5, 8-р саруудад нэг удаа	2 цэгт 2 удаа	50 000	500 000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, , дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2.	Хөрс	Ахуйн бохир усны хаягдал орчимд, шимт хөрсний овоолго, биологийн нөхөн сэргээлтийн талбай, засварын газар, ШТС орчим	5, 8-р саруудад нэг удаа	4 цэгт 2 удаа	Хөрсний хяналт шинжилгээний 1-2 цэгт жилд 2 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 35000 төг Газарзүйн хүрээнийн Хөрсний лаборатрид Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 45.0 мян.төг	330 000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

					“Ханлаб” лаборатори			
3.	Ус	Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур,	5, 8-р саруудад нэг удаа	3 цэгт 2 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 50000 төг, Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 141700 төг *УСУГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ Мөн элс угаан баяжуулах нуурын усанд хүнд металлын шинжилгээ өгнө.	400 000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар)	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/А/171 тоот тушаалын 2-р хавсралт.
Нийт		1 230 000						

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв төг	Хэрэгжүүлэх хуваарь 2025 он	Хариуцсан албан тушаалтан
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод үйл ажиллагааны зардал	Төслийн хугацаанд	Уурхайн дарга
2.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	Дотоод үйл ажиллагааны зардал	11-р сар	“ХОТУ”ХХК-ийн удирдлагууд
3.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих	Дотоод үйл ажиллагааны зардал	Сар бүр	“ХОТУ”ХХК-ийн удирдлагууд

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 14 Менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
1.	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.	9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.
2.		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	11 сарын 1-нд багтаан		
3.		Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.	10-р сараас 12-р сарын 1-нд багтаан		

БҮЛЭГ14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ДҮН

Хүснэгт 15 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Д.д	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	1000000
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	1700000
3	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	300000
4	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	1500000
5	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	2500000
6	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө	500000
7	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	12000000
8	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн зардал	3270000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1230000
	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	24,000,000

Техникийн нөхөн сэргээлтийг ажлыг дотоод овоолгоор хийх бөгөөд энэ ажил нь үйл ажиллагааны зардалд ордог. 2025 онд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийгдэх тул техникийн нөхөн сэргээлтэд тусдаа зардал төлөвлөөгүй болно.

Биологийн нөхөн сэргээлтэд 8 сая төгрөг нэмж төлөвлөв. Нийт нөхөн сэргээлтийн зардал 12 сая төгрөг, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 24 сая төгрөг болсон.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын 50% болох 12000000 төгрөгийг нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр болгон байршуулав.

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-003108 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ БҮХИЙ ЦАГААН ЧУЛУУТ ХООЛОЙН ДУНД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ




Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: S52917003202502253

Татсан огноо: 2025-02-25 13:54

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
3205115640 MN950015003205115640	100900013406	8,000,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ЭГЭ МАЙНИНГ ХХК	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга ХОТУ ХХК MV-003108 ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН 202 Гүйлгээний огноо 2025-02-25	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан		



Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.




Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 324785134

Татсан огноо: 2025-03-13 11:52

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
2010008443 MN290015002010008443	100900013406	4,000,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ЮБИКСОЛЮШН ХХК	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга Хоту ХХК MV-003108 РД2763788 БОМТ барьцаа төлбөр Гүйлгээний огноо 2025-03-13	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан		

Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
Т. ЭРДЭНЭСАЙХАН		

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

2025 оны барьцаа төлбөр төлсөн баримт